



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2012 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А1703

Улаанбаатар хот

**Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр  
гадаадад суралцуулах тухай**

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам, Оросын Холбоон Улсын Дотоод хэргийн яам хоорондын хамтын ажиллагааны хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 19 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Цагдаагийн ерөнхий газрын ахлах байцаагч, цагдаагийн хошууч Дашням овогтой Пандиймаа, Замын цагдаагийн газрын ахлах байцаагч, цагдаагийн хошууч Энэбиш овогтой Бөхбат, Дархан-Уул аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газрын тасгийн дарга, цагдаагийн хошууч Даваасамбуу овогтой Ганзориг, Хэнтий аймгийн Шийдвэр гүйцэтгэлийн албаны дарга, дэд хурандаа Машлай овогтой Алтан-Очир нарыг 2012-2013 оны хичээлийн жилээс Оросын Холбооны Улсын Дотоод хэргийн яамны Удирдлагын академид Сургалтын Төрийн сангийн зээлийн санхүүжилтээр суралцуулсугай.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

Ё.ОТГОНБАЯР